

ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын сангаас олгох
үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс
шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж,
төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн
найруулгын төсөл*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилт “Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ.”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, ...монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-т “хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулж, осол, гэмтлийн улмаас нас барах явдлыг тогтвортой бууруулах, хүн амыг олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх”, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хөдөлмөр, эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-т “...урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх зэргээр үйлдвэрлэлийн осол, гэмтлийн тохиолдлыг бууруулах” гэж тус тус тусгасан.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг 1994 онд баталснаас хойш шимтгэл төлөх, зардал гаргах, урьдчилан сэргийлэх хүрээнд нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

Гэвч үйлдвэрлэлийн ослыг бүртгэх, хяналт тавих, осолд өртсөн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх замаар ажиллах боломж, чадварыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлд эгүүлэн оруулах, өнөөгийн үйлдвэрлэлийн ослын /ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны/ менежментийг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид олгож буй төлбөр, зардлыг төрлөөр авч үзвэл, нийт зардлын 51 хувийг тэтгэвэрт, 3 хувийг тэтгэмжид, 4.0 хувийг хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээх болон рашаан сувилалд сувилуулсны төлбөрт, 1.0 хувийг урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны зардалд, 2 хувийг тахир дутуугийн тэтгэвэр авагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлд тус тус зарцуулж байна. Одоогийн хуулийн гол үзэл баримтлал, зохицуулалт нь тэтгэвэр, тэтгэмж олгох харилцааг ихэвчлэн зохицуулж, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх, осолдогчийг ажлын байранд нь эгүүлэн ажиллуулах хүртэл эрүүл мэндийн болон мэргэжлийн нөхөн сэргээлт хийх, санхүүжүүлэх, салбарын нэгдсэн зохицуулалт хийх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Түүнчлэн үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, сургалтад хамруулах, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зан төлөвийг ажил олгогч болон даатгуулагчид төлөвшүүлэх, осолдогчийг бүртгэх, хяналт тавих, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, ослын эрсдэлийг хянах, мэдээллийн сангийн зохицуулалтын асуудлууд нь нэгдсэн зохицуулалтгүй байна.

Үйлдвэрлэлийн осолтой холбоотой хууль, эрх зүйн давхардал, хийдэл, зохицуулалтгүй асуудлууд бий болсноор даатгуулагч, ажил олгогчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ослоос урьдчилан сэргийлэх, ажил олгогч болон даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг хуваалцах, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн эрх хангагдахгүй байна.

Үйлдвэрлэлийн ослыг бүртгэх, баталгаажуулах чиг үүргийг мэргэжлийн хяналтын байгууллага эрхэлдэг бол ажил олгогч, даатгуулагчид чиглэсэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны ажлыг нийгмийн даатгалын байгууллага зөвхөн сургалтын зардлын хүрээнд санхүүжүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан сургалтын байгууллагын хүрээнд бүтээгдэхүүн худалдан авах зарчмаар зохион байгуулж байна.

Цаашид сургалтын үр дүнг үнэлэх, тасралтгүй сургах, ажлын байрны ажиллах нөхцөлийг сайжруулж, осол гарах эрсдэлийг урьдчилан илрүүлж, осол гаргаагүй ажил олгогчийг урамшуулах, нийгмийн даатгалын байгууллагын чиг үүргийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг цогцоор шийдэх, хуульчлах нь өнөөгийн бодит хэрэгцээ болоод байна.

Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн бодлогыг хөгжүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг хөдөлмөр эрхлэх чадамжид тулгуурлан тогтоох, ингэснээр иргэнийг хөдөлмөрлөх дадал сэдэлтэй болгох, ажил олгогч нь ажилтны нийгмийн баталгааг хангахад хувь нэмрээ оруулдаг тогтолцооны шинэ чиг хандлагыг бий болгох шаардлагатай байна.

Эрүүл мэндийн нөхөн сэргээлт хийх сувиллын тусламж, үйлчилгээний хувьсах зардлыг даатгалын сангаас хариуцаж байгаа ч даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээгдэж буй эсэхийг хянах, үнэлэх зохицуулалтыг хуульчлаагүй, нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээг эрчимтэй үзүүлэх нөхцөл, журам тодорхойгүй байгаа юм.

Иймээс даатгалын сангаас үзүүлэх арга хэмжээ, үйлчилгээний нэр төрөл, хамрах хүрээг өргөтгөх, орлого, зарлагын бүтцийг тодорхой оновчтой болгох, ослоос урьдчилан сэргийлэх, оролцогч талуудын үүргийг нэмэгдүүлэх, уялдааг сайжруулах, даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг бий болгох, үйлдвэрлэлийн осол гарах нөхцөл, эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бүртгэх, хянах, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, сангийн цахим мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох зэрэг харилцааг хуулиар шинэчлэн тогтоох шаардлагатай байна.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 2020 онд 145.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрч, сангаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 4.4 мянган иргэний тэтгэвэрт 27.7 тэрбум төгрөг,

хөдөлмөрийн чадвар түр алдсан 1.1 мянган иргэний тэтгэмжид 0.9 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд 2.1 мянган иргэнд 1.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

| № | Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл | 2018 он | | 2019 он | | 2020 он | |
|---|--|-----------------------|-----------------------------|-----------------------|-----------------------------|-----------------------|-----------------------------|
| | | Тоо /мян.хүн/ / | Хөрөнгө /тэрбум.төг / | Тоо /мян.хүн/ / | Хөрөнгө /тэрбум.төг / | Тоо /мян.хүн/ / | Хөрөнгө /тэрбум.төг / |
| | Тахир дутуугийн тэтгэвэр | 4.3 | 23.9 | 4.0 | 24.2 | 3.9 | 24.8 |
| | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 0.6 | 2.6 | 0.5 | 2.7 | 0.5 | 2.9 |
| | ХЧТА-ны тэтгэмж | 1.1 | 0.7 | 1.1 | 0.7 | 1.1 | 0.9 |
| | Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр | 0.02 | 0.02 | 0.02 | 0.02 | 0.02 | 0.02 |
| | Рашаан сувиллын зардал | 3.4 | 0.9 | 3.2 | 0.9 | 2.1 | 0.6 |
| | Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал | - | 0.8 | - | 1.0 | - | 0.7 |
| | Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл | - | 0.9 | - | 1.2 | - | 1.6 |
| | Нийт | 9.4 | 29.9 | 8.8 | 30.8 | 7.6 | 31.5 |

Тус сан нь орлогоороо зарлагаа нөхөн алдагдалгүй ажиллаж байгаа бөгөөд сангийн мөнгөн хөрөнгө 2020 оны эцэст 109.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хуулийн төслийн зорилт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгох, даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой зардлын төлбөр олгох, санхүүжүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөлд үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон хугацаанд, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтнаа тохирсон ажлын байраар хангасан тохиолдолд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн чөлөөлөлт үзүүлэхээр, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас ихгүй байхаар тусгасан.

Хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэвэр авагчид протез, ортопедын жишиг үнийг баримтлан 5 жилд 1 удаа 100 хувиар, дараагийн удаа 50 хувиар тооцон даатгалын сангаас хариуцаж байсныг 3 жил тутамд 100 хувиар хариуцахаар тусгав.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулсан ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт 3 жилд 10 хувиар тооцон үзүүлдэг байсныг 15 хувь болгон нэмэгдүүлсэн.

Мөн даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж авах өргөдлөө цахимаар өгөх, үйлчилгээг түргэн шуурхай болгоход хуулийн төслийг чиглүүлсэн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар үйлдвэрлэлийн осолд өртсөн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчид эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн үйлчилгээ үзүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, тэдний нийгмийн баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэх, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх шалгуур үзүүлэлт тодорхой болж, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх, хяналт тавих, ослоос урьдчилан сэргийлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирна.

Энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд болон төрийн байгууллага, даатгуулагчид нэмэлт зардал, дарамт үүсгэхгүй харин үйлдвэрлэлийн осолд өртсөн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас жилд нийт 46.7 тэрбум төгрөгийн зардал гарах тооцоо гарч байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР